

Суралцагчийн хөгжил хамгаалал, сургалтын орчны бодлогын удирдлага, зохицуулалт хариуцсан ахлах мэргэжилтэн, Ганжуур Амаржаргал

2024 ОНЫ ХАГАС ЖИЛ-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
1.1. Урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан боловсрол, шинжлэх ухааны салбарт хамаарах арга хэмжээг хэрэгжүүлж ажиллах							
1	Суралцагчийн ялгаатай хэрэгцээг хангах сургалтын орчин, тохирох хэрэглэгдэхүүнийг үе шаттай нэмэгдүүлэх ажлыг удирдлага, зохион байгуулалтаар ханган ажиллана.	Санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэж, тоног төхөөрөмжийг хүлээлгэн өгсөн байна.	-	Худалдан авах ажиллагааг холбогдох хуулийн дагуу зохион байгуулсан байна.	Боловсролын болон дэмжих үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг бүхий цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд 2023-2024 оны хичээлийн жилд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг БШУ-ны сайдын 2023 оны "Төлөвлөгөө батлах тухай" А/467 дугаар тушаалаар батлан хэрэгжүүллээ. - ЕБ-ын 63 дугаар сургуулийн өргөтгөл барихтай холбоотойгоор тус сургуулийн газрын гэрчилгээний хугацааг	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					сунгуулах хүсэлтийг БШУЯ-ны 2024 оны 1а/328, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сувиллын цэцэрлэг байгуулах газрын асуудлыг шийдвэрлүүлэх хүсэлтийг Боловсрол, 1а/550 дугаартай албан бичгээр тус тус БОАЖЯ-нд хүргүүлсэн. -70,116-р сургуулийн дотоод сүлжээний асуудлыг бүрэн шийдвэрлэж, утасгүй дотоод сүлжээг суурилуулсан. 29-р сургууль, 116-р дугаар сургуулийн газрын маргааны асуудлыг шийдвэрлэж, 116-р сургуулийн эзэмшилд дотуур байр барих 5,062т.кв газрыг шилжүүлсэн. БШУЯ-ны 2024 оны 1а/328 дугаар албан бичиг -ТНБД-ын 2024 оны А/06 дугаар тушаалаар байгуулагдсан худалдан авах ажиллагааны техникийн тодорхойлолт боловсруулах ажлын хэсэг 2024 оны ХАА-ны төлөвлөгөөнд тусгагдсан 29-р сургууль-сандал, ширээ		
--	--	--	--	--	--	--	--

					/130 сая₮/, 55, 116-р сургуулиудад лифт /400 сая₮/, 70, 63-р сургуулийн автобус, 10ш смарт дэлгэц, техникийн тодорхойлолтыг боловсруулж, худалдан авах ажиллагааг зохион байгуулж байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан тохируулгат орчин бүхий танхим тохижуулах 17,5 мянган долларын санхүүжилтийг НҮБХС-аас шийдвэрлэж, танхим тохижуулах сургуулийг сонгосон. Мөн багш бүрийг компьютержүүлэх хүрээнд нийт багш нарыг холбогдох тоног төхөөрөмж, хэрэглэгдэхүүнээр үе шаттай хангаж байна. Боловсролын салбарын цахим шилжилтийн хүрээнд EDU TECH нэгдсэн арга хэмжээг 2024 оны 05-р сарын 21-ний өдөр зохион байгуулж, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхэд, тэдний эцэг эх, асран хамгаалагчид төрийн үйлчилгээг хүртээмжтэй авах	
--	--	--	--	--	--	--

					боломжийг бүрдүүлэх зорилготой e-hurteemj цахим платформ болон дохионы хэлний Hand pro апп-ний хөгжүүлэлтийн нээлтийг зохион байгуулж, нийт 300 хүн оролцов. Хавсралт: 5 файл		
2	Цэцэрлэг, сургуулийн багш нарыг ялгаатай хэрэгцээтэй хүүхэдтэй ажиллах арга зүйн сургалтад үе шаттай хамруулах ажлыг удирдлага, зохицуулалтаар хангах.	Сургалтад хамрагдсан багшийн тоо	-	Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн 150 багшийг ялгаатай хэрэгцээтэй хүүхэдтэй ажиллах ара зүйн сургалтад хамруулсан байна.	-Сайдын 2024 оны "Сургалт, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулах, зардал батлах тухай" А/94 дүгээр тушаалыг батлуулж, "Тэгш боломжийг бүрдүүлэх замаар суралцахуйг дэмжих" төслийн нэгдүгээр бүрэлдэхүүнд хамрагдаж буй зорилтот Архангай, Сэлэнгэ, Увс, Сүхбаатар аймгийн болон нийслэлийн СБД, ХУД-ийн 18 ЕБС-ийн дунд ангийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй 187 эцэг, эхчүүдэд "Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх, хэрэгжилтэд үнэлгээ хийхэд оролцох чиглэлээр эцэг эхчүүдийн чадавхыг	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					бэхжүүлэх” сургалт, 8307 сурагчид “Хөгжлийн бэрхшээлтэй үе тэнгийн найзуудаа дэмжих чиглэлээр нийт суралцагчдын мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх” нөлөөллийн арга хэмжээг 2024 оны 04 дүгээр сарын 15-26-ны өдрүүдэд тус тус зохион байгуулсан. /68,551,150 ₮/ Сайдын 2024 оны Сургалт зохион байгуулах, зардал батлах тухай А/93 дугаар тушаалыг батлуулж, “Тэгш боломжийг бүрдүүлэх замаар суралцахуйг дэмжих” төслийн “Тэгш хамран сургах боловсрол” бүрэлдэхүүний зорилтот Архангай, Сэлэнгэ, Увс, Сүхбаатар аймгийн болон нийслэлийн СБД, ХУД-ийн ЕБС-ийн дунд ангийн 2600 багшид “Тэгш хамран сургах боловсролын сургалтын хөтөлбөр, арга зүй, сургалтын орчинд тохируулга хийх, ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэх, суралцагчийг үнэлэх		
--	--	--	--	--	--	--	--

					арга зүй” сэдэвт сургалтыг 2024 оны 04 дүгээр сарын 01-27-ны өдрүүдэд зохион байгууллаа. /286,144,312 ₮/ Жайка ОУБ-тай хамтран хэрэгжүүлж буй Старт-2 төслийн хүрээнд “Тэгш хамран сургах боловсролын хэрэгжилтэд хяналт тавьж, зөвлөн туслах” үйл ажиллагааг зорилтот аймгуудад зохион байгуулж, ХБХ-тэй ажиллаж буй багш нарт сургалт зохион байгуулж, зөвлөн тусалсан. Дэмжих үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг бүхий 55, 63 дугаар сургуулийн багш нарыг 2024.03.25-31-ний өдрүүдэд БНТУ-д хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүйн сургалтад хамруулж, олон улсын туршлага судлах үйл ажиллагаанд оролцуулав. Мөн Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөнд суралцахуйн түгээмэл загварыг ашиглах нь	
--	--	--	--	--	---	--

					сургалтад аймаг, нийслэлийн 200 багшийг хамруулсан. Хавсралт: 6 файл		
1.2. Хүүхдийн хөгжлийн бэрхшээлийн онцлог, суралцах чадамжид суурилан сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, үнэлгээний арга зүйг боловсронгуй болгох ажлыг удирдлага зохицуулалтаар хангах							
3	Тусгай хэрэгцээт суралцагчид элсэлтийн ерөнхий шалгалт өгөх тохируулга хийх ажлыг удирдлага зохицуулалтаар хангах	Элсэлтийн ерөнхий шалгалт өгсөн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо	-	Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчид элсэлтийн ерөнхий шалгалт өгөх тохируулга хийгдсэн байна.	2023-2024 оны хийчээлийн жилд Элсэлтийн шалгалт хуучин журмаар зохион байгуулагдах ба тусгай хэрэгцээтэй хүүхдэд холбогдох тохируулгыг хийсэн. Монгол хэлний шалгалтад оролцсон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд холбогдох тохируулгууд бүрэн хийгдэж, шалгалтыг зохион байгуулсан.	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
4	Боловсролын болон дэмжих үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг бүхий ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн гүйцэтгэлийн үнэлгээ, багш нарын үнэлгээний аргачлалыг шинэчлэн боловсруулах ажлыг удирдлагаар хангах	Шинэчлэн боловсруулсан үнэлгээний аргачлал	Үнэлгээний аргачлал	Боловсролын болон дэмжих үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг бүхий ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн гүйцэтгэлийн үнэлгээ, багш нарын үнэлгээний аргачлалыг шинэчлэх санал боловсруулах	Боловсролын болон дэмжих үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг бүхий ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн гүйцэтгэлийн үнэлгээ, багш нарын үнэлгээний аргачлалыг шинэчлэн боловсруулах ажлыг удирдлагаар хангах Багшийн гүйцэтгэлийн үнэлгээний арга зүй /үнэлгээний арга хэрэгсэл, зохион байгуулах үйл явц, үр	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн

					дүнг тооцох аргачлал зэрэг/-д тохируулга хийж байна. Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолд өөрчлөлт орсны дараа СӨБ, ЕБС, МБСБ-ын багшийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээний журмыг шинэчлэх ажлын хүрээнд боловсролын болон дэмжих үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг бүхий ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн багшийн гүйцэтгэлийн үнэлгээний аргачлалыг тусгахаар ажиллаж байна. Багшийн гүйцэтгэлийн үнэлгээний дата хөгжүүлэлт хийгдэж байна.		байдал: 100%
--	--	--	--	--	---	--	--------------

1.3. Тэгш хамруулан сургах боловсролыг хөгжүүлэх богино хугацааны төлөвлөгөө, сургалтын хөтөлбөр, үнэлгээ, сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүний хүртээмжийг нэмэгдүүлэх, эрхзүйн баримт бичгийг боловсруулах, удирдлага зохицуулалтаар хангах

5	Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд суралцаж байгаа ялгаатай хэрэгцээтэй суралцагчид хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх журмын төсөл боловсруулж, батлуулна.	Засгийн газрын гишүүдийн хамтарсан тушаал	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд цогц дэмжлэг үзүүлэх аргачлал	Журмын төслийг боловсруулж, санал авна.	Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд суралцаж байгаа ялгаатай хэрэгцээтэй суралцагчид хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх журмын төслийг Нийтлэг үндэслэл, Зарчим, Цогц дэмжлэгийн үйл	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ
---	---	---	--	---	---	---	--

					ажиллагааны удирдлага, зохион байгуулалт, Хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах үйл ажиллагаа, Санхүүжилт гэсэн 5 бүлэгтэй боловсруулсан.	сар, 12-р сар	төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
6	Хөгжлийн бэрхшээлтэй хүний боловсрол эзэмшихэд дэмжлэг үзүүлэх дэмжих төвийн бүтэц орон тоо, үйл ажиллагааны дүрмийн төсөл боловсруулж, батлуулна.	Засгийн газрын гишүүдийн хамтарсан тушаал	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд цогц дэмжлэг үзүүлэх аргачлал	Дүрмийн төслийг боловсруулж, хэлэлцүүлнэ.	Дүрмийн төслийг боловсруулж, БШУЯ-ны 2023 оны 2/5122 дугаартай албан бичгээр ЭМЯ, ХНХЯ-наас санал авч тусгасан. -Дэмжих төвийн зохион байгуулалт, бүтэц, үйл ажиллагааны талаар ЭМЯ, ХНХЯ, СЯ-тай хамтарсан 4 яамны уулзалтыг 2024.01.18-ны өдөр 14 цагт ХНХЯ-ны хурлын өрөөнд зохион байгуулсан. 2024.01.26-ны өдөр 16 цагт 111 тоот өрөөнд Сайд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд дэмжих үйлчилгээ үзүүлж байгаа ТББ-уудтай уулзалт зохион байгуулсан. -БЕХ-ийн 17.10-д зааснаар Танхимын сургалтад хамрагдах боломжгүй хөгжлийн бэрхшээлтэй	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					хүний боловсрол эзэмшихэд дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа нь БШУЯ, ЭМЯ, ХНХЯ-ны санхүүжилт бүхий 3 талт цогц үйлчилгээ байх тул бусад салбар дахь одоо мөрдөгдөж байгаа хууль, тогтоомжид нийцүүлэх шаардлагатай байгааг харгалзан холбогдох зохицуулалтуудыг хийн ажиллаж байна. Тухайлбал: -Эрүүл мэндийн тухай хуулийн 8.7-д заасныг хэрэгжүүлэн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн цогц хөгжлийг дэмжихэд хамтарч ажиллах талаар БШУЯ-ны 16/721 дугаартай албан бичгийг ЭМЯ-нд хүргүүлсэн. Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны "Туршилт зохион байгуулах тухай" А/60 дугаар тушаалаар 2023-2024 оны хичээлийн жилд сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын танхимын сургалтад хамрагдах боломжгүй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд хамруулах		
--	--	--	--	--	--	--	--

					зохицуулалтыг хийж, хэрэгжүүлэн ажиллаж байна. Энэ хүрээнд 4 төрийн бус байгууллага, 4 тусгай сургууль, БСҮХ, БҮТ, НБГ, БЕГ хамтран ажиллаж, дэмжих төвийн туршилтын үйл ажиллагааг хэрэгжүүлж байна. Энэхүү туршилтын үйлчилгээнд 130,200,000 төгрөг зарцуулж, танхимын сургалтад тогтмол хамрагдах боломжгүй 78 хүүхдэд дэмжих үйлчилгээ үзүүлж байна. Дүрмийн төслийг дахин боловсруулахаар ТНБД-ын 2024 оны А/60-р тушаалаар ажлын хэсгийг шинэчлэн байгуулж, 4 удаа уулзалт зохион байгуулж, дүрмийн төслийг хэлэлцүүлсэн. Хавсралт: 6 файл		
7	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсрол эзэмшихэд дэмжих төвийн загварыг туршилтаар хэрэгжүүлэх, боловсролд тэгш хамруулах ажлыг удирдлага	- Дэмжих үйлчилгээ үзүүлж буй төвийн тоо, хамрагдсан хүүхдийн тоо - Тэгш хамран сургах чиглэлээр арга зүйг түгээн дэлгэрүүлсэн	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд цогц дэмжлэг үзүүлэх аргачлал	1. Дэмжих үйлчилгээг туршин хэрэгжүүлэх тухай сайдын тушаал батлагдсан байна. 2. Ялгаатай хэрэгцээтэй хүүхдийг боловсролд тэгш	Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны "Туршилт зохион байгуулах тухай" А/60 дугаар тушаалаар 2023-2024 оны хичээлийн жилд сургуулийн өмнөх болон ерөнхий	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын

	зохицуулалтаар хангана.	ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн тоо		хамран сургах сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх ажлын удирдамжийг боловсруулж, сургагч багш нар бэлтгэгдсэн байна.	боловсролын танхимын сургалтад хамрагдах боломжгүй хөгжлийн бэрхшээлтэй 78 хүүхдэд тухайн түвшний боловсролын сургалтын хөтөлбөрт тохируулга хийж, ганцаарчилсан төлөвлөгөөний дагуу ганцаарчилсан сургалтыг туршилтаар зохион байгуулах арга хэмжээ авч, төр болон хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд Ээлтэй ертөнц, Эрхэм нандин сувд, Энэрлийн түүчээ, Аутизмд хийсэн аялал ТББ-тай хамтран хэрэгжүүлэхээр холбогдох зардал /395,522.1₮/, бүртгэл, бусад зохицуулалтыг хийж, хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд: Туршилт сургалтыг зохион байгуулах түшиц цэцэрлэг, сургуулийг сонгон 2024 оны 6 сар хүртэл үр дүнтэй зохион байгуулах, сургалтыг зохион байгуулах багш, багшийн туслахыг сонгон холбогдох сургалтад хамруулах, туршилт сургалтад хамрагдах хөгжлийн	сар, 11-р сар, 12-р сар	үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
--	--------------------------------	--	--	---	---	--------------------------------	--

					бэрхшээлтэй хүүхдүүдийг түшиц цэцэрлэг, сургуулийн бүртгэлд бүртгэх, туршилтын хугацаанд шаардагдах хувьсах зардал, хоолны мөнгийг тооцож олгох, шаардлагатай дэмжих үйлчилгээ үзүүлэх ажлыг Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн хүрээнд зохион байгуулах, тохирох хэрэглэгдэхүүнээр хангах зэрэг зохицуулалтыг хийсэн. Хэрэгжилтийг хангах талаар ТНБД-ын 2/605 албан тоотыг БЕГ, БСҮХ, БҮТ, НБГ-т хүргүүлж, тус байгууллагуудын удирдлага, холбогдох албан хаагчид, туршилт сургалтыг зохион байгуулах түшиц цэцэрлэг, сургуулийн удирдлагатай ТНБД уулзаж, 2024.02.23-ны өдөр үүрэг, чиглэл өгсөн. -Дэмжих төвд хэрэгжүүлэх туршилтын хөтөлбөрийг боловсруулж, БСҮХ-ийн захирлын 2024 оны “Цэцэрлэг сургуульд туршилт зохион		
--	--	--	--	--	--	--	--

					байгуулах тухай "А/09 дүгээр тушаалаар батлан турших түшиц сургууль, цэцэрлэгт хүргүүлж, суралцагчдыг боловсролын мэдээллийн систем /esis/-д бүртгэн сургалт зохион байгуулах санхүүжилтийг шийдвэрлэсэн. Тэгш боломжийг бүрдүүлэх замаар суралцахуйг дэмжих төслийн хүрээнд 35 сургагч багшийг бэлтгэн, удирдамжийн дагуу 18 сургуульд сайн туршлагыг түгээн ажлын байран дээр зөвлөн тусалсан. Хавсралт: 3 файл		
8	Танхимын сургалтад тогтмол хамрагдахгүй байгаа 2-18 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн судалгааг хамран сургах тойргийн сургууль, цэцэрлэг бүрээр нэгтгэн боловсруулах ажлыг удирдлага зохицуулалтаар хангаж, боловсролд хамруулах зөвлөмж боловсруулах	Боловсролд хамрагдахгүй байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн бодит тоог хамран сургах тойргийн сургууль, цэцэрлэгээр нь гаргасан байна. Боловсролд хамруулах зөвлөмж, чиглэл боловсруулж, хүргүүлсэн байна.	-	Судалгааны маягт боловсруулж, хүргүүлсэн байна.	Орон нутгийн насан туршийн боловсролын төв, баг, хорооны засаг дарга, мэргэжилтний дэмжлэгтэйгээр ерөнхий боловсролын сургуулийн гадна байгаа хүүхдийн тоо, шалтгааныг илрүүлэх судалгааг 21 аймаг, 9 дүүргийн 330 сумын 1639 баг, 204 хороонд явуулсан. Судалгаагаар улсын хэмжээнд 3331 хүүхэд сургуулийн	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					гадна байгааг илрүүлсэн бөгөөд байршлаар авч үзвэл баруун бүсийн аймгуудад 911 хүүхэд, хангайн бүсийн аймгуудад 1096 хүүхэд, төвийн бүсийн аймгуудад 347 хүүхэд, зүүн бүсийн аймгуудад 337 хүүхэд, Улаанбаатар хотод 640 хүүхэд тус тус байна. Мөн судалгааны дүнгээс үзэхэд ар гэрийн гачигдал, хөгжлийн бэрхшээл, сурах хүсэл сонирхолгүй зэрэг шалтгаанаар голчлон боловсролд хамрагдаагүй байна. Нийт боловсролд хамрагдаагүй 3331 хүүхдээс 549 хүүхэд хөгжлийн бэрхшээлтэй, 187 хүүхэд эрүүл мэндийн шалтгаанаар завсардсан гэсэн судалгаа гарсан байна. Орон нутгийн БШУГ-ын тэгш хамран сургах боловсролын асуудал хариуцсан албан тушаалтны ажлын байрны тодорхойлолтын гүйцэтгэх чиг үүрэгт "Тэгш хамран сургах		
--	--	--	--	--	---	--	--

					боловсролын бодлогын хэрэгжилттэй холбоотой статистик тоон мэдээллийг батлагдсан маягтын дагуу, хугацаанд нь, үнэн зөв, гаргаж мэдээлэх", "Ялгаатай хэрэгцээтэй хүүхэд бүрийг боловсролын үйлчилгээнд хамруулах, боловсролын гадна үлдсэн хүүхдийг илрүүлэн хариу арга хэмжээ авч ажиллах" гэсэн заалтууд оруулахаар санал өгсөн.		
9	Бага боловсролын казак, тува хэлний сургалтын хөтөлбөр боловсруулах ажлыг удирдлага, зохицуулалтаар хангах	Бага боловсролын казах, тува хэлний сургалтын хөтөлбөрийг шинэчлэн боловсруулсан байна.	-	Бага боловсролын казах, тува хэлний сургалтын хөтөлбөрийн шинэчлэлийн төслийг боловсруулсан байна.	Тува хэлээр сургалт явуулдаг сургуулийн бага ангийн сурагчийн 1-5 дугаар ангид судлах Тува хэлний гарын авлагын агуулга, арга зүйг сайжруулан сургалтад ашиглаж байна. Мөн Хөвсгөл аймгийн Цагаан нуур суманд амьдарч буй эх хэлээрээ суралцахгүй байгаа цаатан хүүхдүүдэд зориулан тува хэлний анхан шатны гарын авлагыг шинэчлэн сайжруулж, сургалтад ашиглаж байна. Засгийн газрын	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					2024 оны 176 дугаар тогтоолоор батлагдсан Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлалд "Өөр хэл бүхий үндэстний цөөнхийн болон олон соёлт гэр бүлтэй суралцагчийн сургалтын агуулга болон хэлийг интеграцчилан заах арга зүй (АХИС)-г баримталж зохион байгуулна" хэмээн тусгасныг үндэслэн Казах болон Тува хэлний сургалтын хөтөлбөрийн төсөл боловсруулж байна. "Хос хэлээр сургалт явуулах АХИС арга зүйгээр хичээлийн төлөвлөлт хийхэд дэмжлэг үзүүлэх" сэдэвт багш нарт зориулсан сургалтыг БЕГ, Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн, аймгийн БШУГ-ууд хамтран зохион байгууллаа. Тус сургалтад захирал, сургалтын менежер, бага, дунд ангийн багш нийт 124 удирдах ажилтан, багш		
--	--	--	--	--	---	--	--

					оролцсон.		
10	Боловсролын болон дэмжих үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг бүхий сургуулийн менежментийг сайжруулах ажлыг удирдлага, зохицуулалтаар хангах	Авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо	БШУС-ын 2023 оны А/467 дугаар тушаал	Төлөвлөгөөнд туссан ажлын гүйцэтгэл 50 хувьд хүрсэн байна.	Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2023 оны Төлөвлөгөө батлах тухай А/467 дугаар тушаалаар боловсролын болон дэмжих үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг бүхий цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд 2023-2024 оны хичээлийн жилд хэрэгжүүлэх үй ажиллагааны төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж байна. Тус төлөвлөгөөнд тусгагдсан тусгай сургуулиудын удирдлага, зохион байгуулалт, сургуулийн менежментийг сайжруулах ажлын хүрээнд дараах ажлыг хийсэн: 1. Тусгай сургуулиуд нийслэлийн харьяанд шилжиж байгаатай холбогдуулан Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2023 оны “Тусгай /хуучнаар/ сургуулийн талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай ”А/573 дугаар тушаалыг батлуулж, БЕГ, НБГ-т	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					болон Улаанбаатар хотын захирагчид сайдын 2024 оны 1а/327 тоот албан бичгийг хүргүүлсэн. НБГ-аас тусгай зөвшөөрлийг сунгуулах, бүтэц орон тоог шинэчлэх ажлыг зохион байгууллаа. 2. Хувьсах зардлын журам шинэчлэн батлагдаж, СӨБ-ын 1 суралцагчид ногдох хувьсах зардал 810,0 аас 1485.0 болж 83.3 хувиар, ЕБС-ийн хувьсах зардлыг анги бүрээр тооцож, дотуур байрны хувьсах зардлыг 355.0 мянгаас 2029.8 мянгад хүргэсэн. Өмнөх оныхтой харьцуулбал, сургууль, цэцэрлэгт хамрагдаж буй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хувьсах зардал СӨБ-ын түвшинд 45,5 хувиар, ЕБС-н түвшинд дунджаар 30.9 хувиар тус тус өсчээ. 3. 55, 63 дугаар сургуулийн ахлах ангийн сурагчдад мэргэжлийн чиг баримжаа олгох, чадамжийн гэрчилгээтэй төгсгөх асуудлыг судалж, 4 удаагийн хамтарсан		
--	--	--	--	--	---	--	--

					уулзалт хийж, мэргэжлийн сургалтын үйл ажиллагаа эрхлэх асуудлаар тус сургуулиудын дүрэм болон улсын бүртгэлийн гэрчилгээнд нэмэлт оруулах чиглэл өгч, хэрэгжүүлсэн. 55, 63 дугаар сургуулийн 11 багшийг чадамжид суурилсан сургалтын хөтөлбөр боловсруулах 48 цагийн сургалтад хамруулсан. Тус багш нар чадамжийн сургалтын хөтөлбөр боловсрууллаа. 4. Туршлага солилцох ажлын хүрээнд 63, 70 дугаар сургуулийн хамтын ажиллагааны төлөвлөгөөнд сургалтын менежерүүдийг 2023-2024 оны хичээлийн жилийн 3-р улиралд сэлгэн ажиллуулахаар тусган хэрэгжүүлж байна. 16 багшийг БНТУ-д сургалтад хамруулав. Хавсралт: 1 файл		
3.1. Төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх							
11	ТАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж	-	-	ТАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөө	Хугацаанд нь боловсруулж, батлуулсан. Тайлан,	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р	Өөрийн үнэлгээ: 100%

	батлуулах, төлөвлөгөөний биелэлтийг тайлагнах			боловсруулж батлуулан биелэлтийг хугацаанд нь тайлагнасан байна.	биелэлтийг цаг хугацаанд нь холбогдох удирдлага, албан хаагчид хүргүүлэн ажиллаж байна.	сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
12	Хөдөлмөрийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх	-	-	Хууль тогтоомжийг хэрэгжүүлэн ажилласан байна.	Хөдөлмөрийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлэн ажилласан.	1-р сар, 2- р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
13	Байгууллагын дотоод журам болон бусад дүрэм, хэм хэмжээг мөрдөнө.	-	-	Байгууллагын дотоод журам болон бусад дүрэм, журам, хэм хэмжээг мөрдөн ажилласан байна.	Байгууллагын дотоод журам болон бусад дүрэм, журам, хэм хэмжээг мөрдөн ажилласан.	1-р сар, 2- р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын

						сар, 12-р сар	үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
--	--	--	--	--	--	---------------	---

НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ

№	Үүрэг даалгавар	Өгсөн субъект	Биелэлт
1	2	3	4

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
			3	4	5	6	7
4.1. Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх							
1	Эрх зүйн боловсролоо дээшлүүлэх	Байгууллагын албан хаагчдын мэдлэг, чадварыг дээшлүүлэх зохион байгуулалттай сургалт, хөгжлийн хөтөлбөрт хамрагдсан байна.	-	Сургалт, хөтөлбөрт хамрагдаж, хариуцсан асуудлын чиглэлээрх болон бусад хууль, тогтоомжийг чанд мөрдөж, ёс зүйн зөрчилгүй ажилласан байна.	Хариуцсан ажлын чиглэлээр холбогдох хууль, тогтоомжийг судлан ажилласан.	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100%
2	Төрийн худалдан авах ажиллагааны сургалтад хамрагдах	Төрийн худалдан авах ажиллагааны сургалтад хамрагдаж, А-3 сертификат авсан байна.	-	Төрийн худалдан авах ажиллагааны сургалтад хамрагдаж, А-3 сертификат авсан байна.	2024.02.23-ны өдөр Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100%

					танилцуулга сургалтад хамрагдаж, 2024/1837 дугаартай гэрчилгээ авсан. Хавсралт: 1 файл		
--	--	--	--	--	---	--	--

ТАЙЛАН ГАРГАСАН:

Суралцагчийн хөгжил хамгаалал, сургалтын орчны бодлогын удирдлага, зохицуулалт хариуцсан ахлах мэргэжилтэн, Ганжуур
Амаржаргал /...../ Огноо: